



НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

「Худалдаа, үйлчилгээний газрын гадна  
орчинд хамаарах хотын стандарт батлах  
тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт; Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэг, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10<sup>1</sup> дүгээр зүйлийн 10<sup>1</sup>.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн Худалдаа, үйлчилгээний газрын гадна орчин бүлэгт хамаарах дор дурдсан стандартуудыг хавсралтаар баталсугай. Үүнд:

1.1. UCS1201B:2022 “Худалдаа, үйлчилгээний газрын гадна орчны ерөнхий шаардлага” хотын стандартыг нэгдүгээр хавсралтаар;

1.2. UCS 1202B:2022 “Худалдаа, үйлчилгээний газрын гадна сурталчилгааны байгууламжид тавигдах ерөнхий шаардлага” хотын стандартыг хоёрдугаар хавсралтаар;

1.3. UCS1203B:2022 “Амралтын газар, жуулчны баазын гадна болон дотоод орчны тохижилт, зохион байгуулалтад тавигдах ерөнхий шаардлага” хотын стандартыг гуравдугаар хавсралтаар;

2. Батлагдсан хотын стандартуудыг мөрдүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д даалгасугай.

3. Энэ тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110100063